



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 4/138

Мөрөн сум

Мөсөн замын тээвэрлэлтийг
хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 94 дүгээр зүйлийн 94.1, аймгийн Шуурхай штабын 2023 оны 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвөөс ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн мөсөн бүрхүүлийн зузаан нимгэрч байгаатай холбогдуулан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн мөсөн замаар авто тээврийн хэрэгслээр зорчихыг хориглосугай.

2. Мөсөн замаар авто тээврийн хэрэгслээр зорчих тээвэрлэлтийн үйл ажиллагааг зогсоож, хяналт тавьж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж, хамтран ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, (хурандаа Ё.Пүрэвсүрэн), Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа А.Алтанцоож), Авто тээврийн төвийн дарга (Ө.Баттулга), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (П.Мөнхжаргал) нарт тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР